



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 06 сарын 30 өдөр

Дугаар А/192

Улаанбаатар хот

Нийслэлийн ерөнхий боловсролын
44 дүгээр сургуулийн эргэлтийн бус хөрөнгийг
данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 19,009,708.25 (арван есөн сая есөн мянга долоон зуун найман төгрөг хорин таван мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан ном, сурах бичгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 44 дүгээр сургууль (Ж.Чимэдзаяа)-д зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй 12165 ширхэг нийт 19,009,708.25 (арван есөн сая есөн мянга долоон зуун найман төгрөг хорин таван мөнгө) төгрөгийн үнэ бүхий ном, сурах бичгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгаж, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 44 дүгээр сургууль (Ж.Чимэдзаяа)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА



М.БАЯРАА

ТУШААЛ-2021

115050000587

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2021 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн А/19 дугаар тушаалын хавсралт



Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянзүрх дүүргийн 44 дүгээр сургууль

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжээ	Тоо хэмжээ	Нэгж	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ЭБХХХК-ийн хурлын шийдвэр
Номын фонд										
1	Ном, сурах бичиг	5-41 жил	ш	12165	ширхэг	19,009,708.25	19,009,708.25		Агуулга стандарт өөрчлөгдсөн, эрүүл ахуйн шаардлага хангахгүй болсон.	Устгах
Номын фондын дүн						19,009,708.25	19,009,708.25			
Нийт данснаас хасах хөрөнгийн дүн										
Үүнээс: Худалдах хөрөнгө										
Устгах хөрөнгө						19,009,708.25	19,009,708.25			
Худалдсанаас олох орлого										
НӨАУГ-т төвлөрүүлэх /30%/										